



Шинжээчийн үнэлээний тайлан

Байгууллагын нэр: Этүгэн их сургууль

Хөтөлбөрийн нэр: Нягтлан бодох бүртгэл, бакалаврын хөтөлбөр

Индекс: 041101

Шинжээчийн баг:

Ахлагч: Д.Оюунцэцэг

Гишүүд: А.Цэнгүүнжаргал

..... Ц.Пүрэвтуяа

Он сар өдөр: 2023.06.06

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

V. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

АНУ	Америкийн нэгдсэн улс
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БСШУ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ИЭЗМС	Инженер, эдийн засаг, менежментийн сургуулт
МУИС	Монгол улсын их сургууль
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББХ	Нягтлан бодох бүртгэл хөтөлбөр
НББХ	Нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөр
ОХУ	Оросын Холбооны Улс
СЭЗИС	Санхүү, эдийн засгийн их сургууль
ХЕХ	Хөтөлбөрийн ерөнхий хороо
ЭЗМТ	Эдийн засаг, менежментийн тэнхим
ЭИС	Этүгэн их сургууль

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Этүгэн Их сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Нягтлан бодох бүртгэл, бакалаврын хөтөлбөр	
Индекс	041101	
Шинжээчид	<p>Д.Оюунцэцэг (доктор, дэд профессор), <i>МУИС-ийн Худалдаа үйлдвэрлэлийн сургуулийн НББ, санхүүгийн тэнхимийн эрхлэгч</i></p> <p>А.Цэнгүүнжаргал Боловсролын Ерөнхий Газрын Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээний газрын Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн</p> <p>Ц.Пүрэвтуяа (доктор, дэд профессор) СЭЗИС-ийн НББ-ийн тэнхимийн багш</p>	
БМИҮЗ-ийн ажлын албаны мэргэжилтэн	Магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч Б.Оюунцэцэг	
Төлөвлөгөө	2023.05.16	Мэргэжилтэн шинжээчдэд ӨҮТ-г хүлээлгэн өгөх
	2023.05.23	Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд өгөх
	2023.05.24	Сургуулийн бэлэн байдлыг нягтлах
	2023.05.26,29	Шинжээчид сургууль дээр ажиллах
	2023.06.06	Шинжээчийн баг зохицуулагчид шинжээчийн тайланг илгээх
		Магадлан итгэмжлэлд орж буй сургуульд шинжээчийн тайланг илгээх
		Сургууль шинжээчийн тайлантай танилцаж хариу өгч, шинжээчийн тайлан эцсийн байдлаар бэлэн болох
		Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр гарах
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ний өдрийн 08 дугаар тогтоолоор батлагдсан “Шалгуур, шаардлага шинэчлэн батлах тухай” тогтоолын Гуравдугаар хавсралтаар батлагдсан шалгуур шаардлагын дагуу ажиллав.	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Боловсрол, соёл, шинжлэх ухаан (цаашид БСШУ гэх)-ы сайдын 2001 оны 153 тоот тушаалаар анх Этүгэн коллеж байгуулагдаж, нягтлан бодох бүртгэл (цаашид НББ гэх), нөхөн сэргээх эмчилгээ мэргэжлээр сургалтын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлөө авсан. БСШУ-ы сайдын тушаалаар 2007 онд дээд сургууль, 2015 онд их сургууль болсон. 2007, 2012, 2022 онд магадлан итгэмжлэгдсэн.

Этүгэн их сургууль (цаашид ЭИС гэх) 2012 онд АНУ-ын Бизнесийн сургууль, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн холбоо ACBSP (Accreditation Council for Business Schools and Programs)-нд гишүүнээр элсэж, 2013 онд менежмент, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний менежмент, аялал жуулчлал, сувиллын менежмент гэсэн 5 хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлсэн сертификатаа хүлээн авсан.

ЭИС 4 бүрэлдэхүүн сургууль, нэг салбар сургуулийн хүрээнд бакалаврын 20 хөтөлбөр, магистрын 6 хөтөлбөр, докторын нэг хөтөлбөр хэрэгжүүлж байна. 2022-2023 оны хичээлийн жилд, нийт 7200 суралцагч, 321 багш, ажилтантай үйл ажиллагаа явуулж байна. Үүний дотор НББХөтөлбөрөр 78 суралцаж, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч 23 багш ажиллаж байна. Сургууль үүсгэн байгуулагдсанаас хойш нийт 7000 гаруй төгсөгчийг бэлтгэн гаргасан.

ЭИС “2030 он гэхэд Азийн шилдэг залуу 100 сургуулийн түвшинд хөгжиж, дараагийн 50 жилд дэлхийн шилдэг 100 сургуулийн түвшинд өрсөлдөнө” гэсэн Алсын хараатайгаар “Хүн чанар, мэргэжлийн ур чадвараараа шилдэг нь болж хөгжих боломж олгодог, үндэсний болон олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх, нээлттэй, судалгааны инноватив их сургуулт болж хөгжинө” гэсэн эрхэм зорилго тавин ажиллаж байна.

Энэ зорилгын хүрээнд НББХ-ийн зорилгыг “НББ-ийн онолын мэдлэг, практик үйл ажиллагааны цогц чадварыг эзэмшсэн, харилцааны соёл, мэргэжлийн ёс зүйн төлөвшилтэй, бүх шатны төрийн болон төрийн бус бизнесийн байгууллагад ажиллах мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн, хөрвөх ур чадвартай нягтлаг бодогч бэлтгэхэд оршино” гэж тодорхойлон, 4 зорилт дэвшүүлсэн. Хөтөлбөрийн хүрэх үр дүнг PLOs (Program Learning Outcomes) 19 ур чадвар, 80 шалгуур үзүүлэлтэйгээр тодорхойлсон.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

НББХ-т мониторинг хийх шалгуур үзүүлэлтийг тогтоохдоо БСШУС-ны сайдын 2014 оны А/174 тоот тушаалаар батлагдсан “Баклаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-ын дагуу НББХ-ийг боловсруулсан. Боловсролын зах зээлийн чиг хандлага, оролцогч талуудаас авсан судалгаанд үндэслэн сургалтын хөтөлбөрийг боловсруулалт, сайжруулалтыг хийдэг.

Илрэл нотолгоо:

- БСШУС-ын сайдын 2014 оны А/174 тоот тушаалаар батлагдсан “Баклаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”;
- 2016-2017 оны хичээлийн жилээс үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх тухай ЭИС-ийн ректорын 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 30 тоот тушаал;
- Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрөөр сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах тухай ЭИС-ийн ректорын 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 102 тоот тушаал;
- ЭИС-ийн хөтөлбөрийн ерөнхий, салбар, дэд хорооны хурлын тэмдэглэлүүд;
- ЭИС-ийн НББ бакалаврын хөтөлбөр, 2023;
- НББХ-ийн өөрийн үнэлгээний тайлан;
- Хөдөлмөрийн зах зээлийн брометрийн судалгаа, 2021;
- Ажил олгогчоос авсан судалгаа, 2018-2022;
- Төгсөгчдөөс авсан асуулга, 2018-2022;
- ЭИС-ийн Багшийн сэтгэл ханамжийн судалгааны эмхэтгэл, 2022;
- МУИС, МБИС, СЭЗИС-ийн бакалаврын НББХ-ийн харьцуулсан судалгаа, 2022;
- Ажил олгогчтой хийсэн цахим уулзалт;
- Төгсөгчидтэй хийсэн цахим уулзалт;

Онцлог зүйл:

- Үр дүнд суурилсан “Бакалаврын сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүй, аргачлалын эмхэтгэл”-ийг боловсруулан хэвлүүлж 2021 оны 6 дугаар сарын 24-ны өдөр “Оюуны өмчийн гэрчилгээ” авсан.
- Өөрийн сургуулийн НББХ-ийг дотооддоо тэргүүлэгч МУИС, МБИС, СЭЗИС-ийн хөтөлбөртэй харьцуулсан судалгаа хийж, хөтөлбөрийн сайжруулалт хийсэн.
- Хөтөлбөрийг тэнхим нэгж, сургуулийн хөтөлбөрийн хороогоор 2-3 удаа хэлэлцүүлэн батлуулж, зохих шинэчлэл, сайжруулалтыг хийж ажилладаг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн хувьд мэргэжлийн холбоодын санал, зөвлөмжийг тусгайлан авч тусгаагүй.

- Олон улсын жишиг шаардлага, олон улсын ижил төрлийн хөтөлбөрүүдтэй харьцуулсан хөтөлбөрийн давуу, болон сул талыг тодорхойлсон судалгаа хангалтгүй.
- Дэлхийн эдийн засгийн форумаас тодорхойлсон зарласан ирээдүйн ажлын байранд хамгийн их эрэлттэй байх 15 ур чадварыг өөрийн хөтөлбөрөөр олгох ур чадвартай харьцуулан судалсан боловч технологийн ашиглалт, дизайн, мониторинг хийх чадвар гэх мэт орчин цагт чухлаар шаардагдаж байгаа цахим орчинд ажиллах ур чадварыг хөтөлбөрт тусгаагүй.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хөтөлбөртэй холбоотой асуудлаар мэргэжлийн холбоод, байгууллагуудаас санал асуулга авч, хөтөлбөрийн шинэчлэл, сайжруулалтад тусган ажиллах;
- Аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгалын үед хамгийн ихээр шаардагдаж байгаа цахим орчинд ажиллах чадварыг хөтөлбөрөөр олгох тал дээр анхаарч ажиллах;
- Гадаадын ижил төстэй их, дээд сургуулийн НББХ-ын агуулгыг өөрийн хөтөлбөртэй харьцуулан судалж, бенчмарк хийх.

Шаардлага: Байхгүй.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Хөтөлбөрийн зорилго, зорилт, НББХ-ийн хүрэх үр дүн (PLO), төгсөгчийн загварыг цаг үеийн нөхцөл байдал, зах зээлийн болон оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд үндэслэн боловсруулж, цаг үеийн нөхцөл байдал, холбогдох судалгаа, санал асуулгын дагуу шинэчилсэн

Илрэл нотолгоо:

- Дэлхийн Эдийн засгийн форумаас зарласан ирээдүйн ажлын байранд хамгийн их эрэлттэй байх 15 ур чадвар;
- ЭИС, Сингапурын их сургууль болон Калифорнийн Баптистын их сургуулийн НББХ-ийн зорилго, зорилтын харьцуулан судалгаа;
- ЭИС-ийн алсын хараа, эрхэм зорилго;
- ЭИС-ийн НББ бакалаврын хөтөлбөр, 2023;
- ЭИС-ийн НББХ-ийн сургалтын төлөвлөгөө;
- Ажил олгогчоос ажлын байранд чухалчилж авч үздэг ур чадварын талаар авсан судалгаа, 2020;
- STEEP шинжилгээ;
- ЭИС-ийн төгсөгчийн загвар.

Онцлог зүйл:

- Хөтөлбөрийн зорилгыг мэргэжлийн болон ороолцогч талуудын хэрэгцээ шаардлагад нийцүүлэх зорилгоор 2020 онд НББ мэргэжилтэнд шаардагдах ур чадварын талаар 57 ажил олгогчоос авсан судалгаа болон Дэлхийн эдийн засгийг форумаас зарласан ирээдүйн ажлын байранд шаардагдах 15 ур

чадвартай ЭИС-ийн хэрэгжүүлж буй НББХ-өөр олгох ур чадварыг харьцуулан судалсан.

- БСШУЯ, Азийн хөгжлийн банкны захиалгаар дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд зөвлөх үйлчилгээ авч төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлсон.
- Сингапурын их сургууль болон Калифорнийн Баптистын их сургуулийн НББХ-ийн зорилго, зорилтыг харьцуулан судалж өөрийн сургуулийн хөтөлбөрийн зорилго, зорилт, суралцахуйн үр дүнг шинэчлэхэд ашигласан.
- 2020 онд “Ажил олгогдоос авсан судалгаа”-гаар ажил олгогдчын тодорхойлсон 17, Дэлхийн эдийн засгийн форумас зарласан ирээдүйн ажлын байранд хамгийн их эрэлттэй байх 15 ур чадварыг ЭИС-ийн НББХ-т тусгасан хөтөлбөрөөр олгох ур чадвартай харьцуулан судалж дүгнэлт өгсөн.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн зорилго, зорилт, үр дүнг тодорхойлох зорилгоор хийсэн STEEP шинжилгээ дутуу, алдаатай.
- Хөтөлбөрийн зорилго, зорилт (PEO) болон суралцахуйн үр дүн (PLO), хичээлийн болон тухайн сэдвийн үр дүнгийн хоорондын уялдаа холбоог зарим хичээлийн хувьд алдаатай тодорхойлсон.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж: /Анхаарах асуудалд чиглэсэн байна/

- Хөтөлбөрийн, хичээлийн, сэдвийн суралцахуйн үр дүнгийн уялдаа холбоог зөв тодорхойлж хичээлийн хөтөлбөрт тусгах.

Шаардлага: /Хэсэгчлэн хангасан, хангаагүй үед заавал бичнэ/

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ЭИС-ийн “Цахим үнэлгээний журам, ЭИС-ийн захирлын 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 11 тоот тушаалын нэгдүгээр хавсралт;
- ЭИС-ийн “Үнэлгээний төлөвлөлтийн нэгдсэн удирдамж”, ЭИС-ийн ректорын 2018 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 89 тоот тушаалын хавсралт;
- ЭИС, Инженерчлэл-эдийн засаг, менежментийн сургууль, эдийн засаг, менежментийн тэнхим. НББХ-ийн идэвхтэй сургалтын арга зүйн анализ: 2021-2022;
- НББХ-ийн сайжруулалт, боловсруулалтын тайлан, 2020-2021 оны 1 дүгээр улирал; НББХ-ийн сайжруулалт, боловсруулалтын тайлан, 2021-2022 оны 1 дүгээр улирал;
- ЭИС-ийн НББХ-т тусгагдсан хичээлүүдийн даалгаврын сан;
- Үнэлгээний зөвлөмж гарын авлага, 2018;
- НББХ-ийн үр дүн болон хичээлийн үр дүнгийг рубрикийн анализ, 2022;
- Багшийн сэтгэл ханамжийн судалгааны эмхэтгэл, 2022;
- Ажил олгогч, төгсөгчидтэй хийсэн цахим уулзалт.

Онцлог зүйл:

- Даалгаврын санг блюпринт, блүүмийн таксономийн 6 түвшингийн дагуу боловсруулж, үнэлгээнд ашигладаг.
- Үнэлгээнд өөрийн үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээ, харьцуулсан үнэлгээг ашигладаг.
- Хичээлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор “Үнэлгээний төлөвлөлтийн нэгдсэн удирдамж” боловсруулан мөрдөж байна.
- Суралцагч, төгсөгчдөөс сургалтад хэрэглэж буй арга зүйн хэрэгжилтийн талаар тогтмол санал асуулга авч хэвшсэн.
- Сургалтын хөтөлбөрийн үр дүн, хичээлийн хөтөлбөрийн үр дүнгийн хэрэгжилтэд шинжилгээ хийж, тэнхимийн төлөвлөгөөнд үнэлгээний аргачлал, даалгаврын санг баяжуулах, сайжруулах талаар тусган ажилладаг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тодорхойлохдоо төгсөгчийн карьер хөгжил, ажлын байрны боломжийг хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадвартай хольж бичсэн.
- Төрийн байгууллагын НББ-ийн онцлог, бүртгэлийн программ дээр ажиллах ур чадвар олгох тал дээр анхаарч ажиллах шаардлагатай.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг дахин нягталж, холбогдох судалгаа, оролцогч талуудын санал, зөвлөмжид үндэслэн сайжруулах;
- Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программ дээр ажиллах чадвар олгох тал дээр анхаарах;
- Мэргэжлийн байгууллага, холбоодоос хөтөлбөрийн үр дүн, агуулгын талаарх санал, зөвлөмжийг байнга авч хөтөлбөрийн шинэчлэлт, сайжруулалтыг хийж байх.

Шаардлага: Байхгүй.

ШАЛГУУР 1.

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Сургалтын хөтөлбөрийн тасралтгүй сайжруулалтыг хийдэг. Уг ажлын хүрээнд хичээлийн хөтөлбөрийн нэгдсэн загварыг гаргаж, 2 жил тутамд сайжруулалт хийн мөрдөж ажилласан.

Илрэл нотолгоо:

- ЭИС-ийн мэргэжлийн хөтөлбөрийн зөвлөмж боловсруулах ажлын хэсгийг байгуулах тухай ЭИС-ийн ректорын тушаал. 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 30 тоот тушаал;
- ЭЗМТ-ийн үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай хурлын протоколууд;
- Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөр-Бидний оролцоо- 2017-2018 оны хичээлийн жилийн 11.25-ны сургалтаас гарсан шийдвэр;
- ЭИС-ийн “НББХ-өөр дамжаа бүрт эзэмших чадвар”. 2018.10.10;
- ИЭЗМС, ЭЗМТ. Хамтын ажиллагааны гэрээ.

Онцлог зүйл:

- Дамжаа бүрт НББХ-өөр оюутны эзэмших ур чадварыг тодорхойлон хяналт тавьж ажилладаг.
- Хичээлийн хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлон, суралцагчдаас улирал бүр, төгсөгчдөөс жил бүр сэтгэл ханамжийн судалгаа авч, цаашдын ажилдаа тусган ажилладаг.
- Хичээлийн хөтөлбөрийн үр дүн болон хичээлийн үр дүнгийн хамаарлыг 4 төрлийн матрицаар үнэлж, хичээлийн хөтөлбөрийн сайжруулалтад тусгадаг.
- Хичээл хоорондын босоо болон хэвтээ залгамж холбоог тодорхойлон гаргасан.
- Дадлагын удирдамжийг нэгдсэн нийтлэг шаардлагын дагуу боловсруулж, сайжруулан, 2017-2022 оны хооронд нийт 56 байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд оюутныг дадлагад гаргах гэрээ байгуулан ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Дадлагын талаар хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хийсэн судалгаа, дүгнэлт хязгаарлагдмал байна.
- Хөтөлбөрийн модыг мөрдөж ажилладаггүй.
- Оюутнууд багш болон хичээл сонгох боломж хязгаарлагдмал.

Үнэлгээ: *Бүрэн хангасан*

Зөвлөмж:

- Дадлагын талаар хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хянах;
- НББХ-ийн модны дагуу хичээлийн өмнөх болон дараах уялдаа холбоог сургалтын үйл ажиллагаанд мөрдөж ажиллах.
- Оюутан хичээл болон багшаа сонгох боломжоор хангах.

Шаардлага: Байхгүй

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

“Сургалтын нэгдсэн журам”-даа хичээлийг идэвхтэй аргаар зохион байгуулах талаар тусгаж, хэрэгжилтийг суралцагч, төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа, багшийн ээлжит хичээлийн өөрийн үнэлгээгээр үнэлдэг.

Илрэл нотолгоо:

- ННБ бакалаврын сургалтын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан;
- Батлагдсан сургалтын төлөвлөгөө, 2023;
- ЭИС-ийн “Сургалтын нэгдсэн журам”;
- ЭИС-ийн “Хөндлөнгийн үнэлгээ хийх журам”;
- ЭИС-ийн багш нарын сургалтад ашиглаж буй идэвхтэй аргын судалгаа, 2022;
- УМС-ийн багш цэсний Багшийн хөгжил, технологийн сан хэсэгт байршуулсан Сайн туршлага, Сайн хичээл файлын сан;
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа;
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа.

Онцлог зүйл:

- НББ-ийн сургалтын төлөвлөгөөнд “Кейс сургалт”-ыг 3 багц цагаар оруулж, бодит кейс дээр, цогц бодлогоор дамжуулан оюутнуудад практик ур чавдар олгодог. Багшийн сургалтын үйл ажиллагааг 7 хоног бүр 3 төрлөөр үнэлдэг. Багшийн өөрийн үнэлгээ, тэнхимийн болон сургалтын албаны үнэлгээний зөрүү хэр байгааг харж, дүгнэлт хийн сургалтыг сайжруулахад чиглүүлж ажилладаг.
- УМС-д Сайн хичээл, Сайн туршлага гэсэн цэс байрлуулж, багш нар харилцан бие биенээсээ суралцах боломжийг олгодог.
- Багш нарын заах арга зүйг дээшлүүлэх зорилгоор гаднын болон өөрийн сургуулийн багш нарын сайн туршлагыг хуваалцах семинар зохион байгуулдаг.
- Сургалтад ашиглаж буй арга зүйн судалгааг дамжаа тус бүрээр хийсний дээр идэвхтэй сургалтын зарчмын талаар сэтгэл ханамжийн судалгааг жил бүр хийж хэвшсэн.

Анхаарах асуудал: Байхгүй

Үнэлгээ: *Бүрэн хангасан*

Зөвлөмж: Байхгүй

Шаардлага: Байхгүй.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхдээ БШУ-ны сайдын 2021 оны А/348 тоот тушаалаар баталсан “Дээд боловсролын зэрэг олгох багц цагийг хэрэглэх, дүйцүүлэх, суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхэд баримтлах

үлгэрчилсэн журам” болон ЭИС-ийн Сургалтын нэгдсэн журам, Үнэлгээний төлөвлөлтийн нэгдсэн удирдамжийн дагуу үнэлж, хяналт тавин сайжруулдаг.

Илрэл нотолгоо:

- БШУ-ны сайдын 2021 оны А/348 тоот тушаалаар баталсан “Дээд боловсролын зэрэг олгох багц цагийг хэрэглэх, дүйцүүлэх, суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхэд баримтлах үлгэрчилсэн журам”;
- ЭИС-ийн “Сургалтын нэгдсэн журам”;
- ЭИС-ийн “Төгсөлтийн шалгалтын журам”, 2018.
- ЭИС-ийн “Үнэлгээний төлөвлөлтийн нэгдсэн удирдамж”, ЭИС-ийн ректорын 2018 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 89 тоот тушаалын хавсралт;
- Дунд шатны НББ-1 хичээлийн рубрикийн 5 дугаар түвшнээр оюутнууд өөрийгөө үнэлсэн үнэлгээ, 2022-2023 оны нэгдүгээр улирал;
- Тэнхимийн үйл ажиллагааны тайлангууд;
- ЭЗМТ-ийн дотоод санамж бичиг, багшийн ажлын төлөвлөгөө, тайлангууд.

Онцлог зүйл:

- 2017-2018 оны хичээлийн жилээс эхлэн блүүмийн таксономийн түвшин бүрээр дамжаа тус бүрд харгалзах даалгаврын сангийн блюпринтийг тодорхойлж
- 2020-2021 оны хичээлийн жилээс эхлэн суралцагчдын эзэмших мэдлэг, чадвар, хандлагын үнэлгээний шалгуурыг рубрикээр гаргаж, хичээлийн агуулгын давтамж, гүнзгийрэл, даалгаврын сантай уялдуулан шинжилгээ хийж, сайжруулж байна.
- Оюутнаар өөрийн үнэлгээг хийлгэж, багшийн болон хамтран суралцагчдын үнэлгээтэй харьцуулан дүгнэлт хийж тэнхимийн хурлаар хэлэлцэн, зөвлөмж гаргадаг.

Анхаарах асуудал: Байхгүй

Үнэлгээ: *Бүрэн хангасан*

Зөвлөмж: Байхгүй

Шаардлага: Байхгүй

ШАЛГУУР 2.

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Сургалт, судалгаа явуулах анги, танхим, лаборатори, оюутны дотуур байр, эмнэлэг, олон улсын шаардлага хангасан спорт заал, усан бассейн зэрэг суралцагч, багш,

ажилтны суралцах, ажиллах таатай орчинг бүрдүүлж, үе шаттайгаар засвар тохижилтийн ажлыг хийж байгаа. Нэг оюутанд ногдох стандарт талбайн шаардлагыг хангасан анги, танхимтай. Сургуулийн хэмжээнд нийт хичээлийн 5 байр, 2 номын сан, Этүгэн Мед үүдэн эмнэлэг, суралцагч хөгжүүлэх төвүүд, оюутны 2 дотуур байртай. Сургалтын орчинг

Илрэл нотолгоо:

- ЭИС-ийн НББ бакалаврын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан, 2023;
- “Сургалтын шилдэг орчинтой сургууль”-аар батламжилсан өргөмжлөл;
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа: Сургалтын орчин, хичээлийн жил тус бүрээр;
- Төгсөгчийн сэтгэл ханамжийн судалгаа: Сургалтын орчин, хичээлийн жил тус бүрээр.

Онцлог зүйл:

- Олон улсын шаардлагад нийцсэн сургалтын орчинг бүрдүүлэх зорилго тавин ажилладаг.
- 2014 онд Монгол Улсын Засгийн газрын газар, МОХ-ноос “Сургалтын шилдэг орчинтой сургууль”-аар өргөмжилсөн.
- 2019 онд бүрэн тоноглогдсон дуу бичлэгийн студийг ашиглалтад оруулсан.
- НББХ-ийн хүрээнд ашиглагддаг мэргэжлийн лаборатори, анги танхимуудын тохижилт, засвар үйлчилгээнд зориулсан хөрөнгө оруулалтын төслүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлж, түүнд зарцуулах төсөв жилээс жилд нэмэгдэж байна.
- НББ хөтөлбөрөөр суралцагч, төгсөгчдөөс жил бүр сургалтын орчны талаарх сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны мөрөөр шаардлагатай арга хэмжээ авч ажилладаг.

Анхаарах асуудал:

- Сурацагч болон төгсөгчдийн сургалтын орчны талаарх сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээс үзэхэд сургалтын орчинд сэтгэл огт ханамжгүй гэж хариулсан хариултын эзлэх хувийн жин өсөж, маш их ханамжтай гэж хариулсан хариултын хувийн жин жил дараалан буух хандлагатай байна.
- “Этүгэн Харзтай” дадлагын бааз газрын ашиглалтын талаарх мэдээлэл, судалгаа байхгүй.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Суралцагч, төгсөгчдөөс сургалтын орчны талаар авсан сэтгэл ханамжийн судалгааны мөрөөр авах арга хэмжээг сайжруулах
- “Этүгэн Харзтай” дадлагын бааз газрын ашиглалтыг сайжруулж, эргэлтэд оруулах.

Шаардлага: Байхгүй

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалтын талаарх сэтгэл ханамжийн судалгаа;
- ЭИС-ийн дүрэм, журмын эмхэтгэл, 2015
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж;
- Цахим сургалтын материал, аудио, видео хичээлүүд;

Онцлог зүйл: /Давуу тал, сайн туршлага г.м/

- Танхим болон цахимаар сургалт явуулах хичээлийн багц материалыг багш бүр жигд сайн бэлтгэсэн.
- Оюутан тухайн хичээл, сэдэвтэй холбоотой сургалтын хэрэглэгдэхүүнийг УМС-ээс авч ашиглах боломж бүрдсэн.

Анхаарах асуудал: Байхгүй

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж: Байхгүй

Шаардлага: Байхгүй

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- ЭИС-ийн Стратеги төлөвлөгөө;
- ЭИС-ийн ном, сурах бичгийн судалгаа;
- Мэргэжлийн ном, сурах бичгийн хүрэлцээ хангамжийн талаарх оюутны сэтгэл ханамжийн судалгаа, 2021, 2022;
- ЭИС-ийн Цахим сургалтын журам, 2020;
- ЭИС-ийн Цахим хичээл бэлтгэх удирдамж.

Онцлог зүйл:

- Лаборатори, сургалтын хэрэглэгдэхүүний ашиглалтын үнэлгээ, давтамж, тайланг улирал бүрээр гаргаж шаардлагатай зүйлсийг дараагийн хичээлийн жилийн төсөвт тусган хангадаг.
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийг ЭИС-ийн цахим хуудас, УМС дээр байршуулан мэдээлж, мөрдүүлэн ажилладаг.
- Өөрийн сургуулийн дуу бичлэгийн студид бэлтгэсэн аудио, видео цахим хичээлийг УМС-д байршуулан сургалтад ашигладаг.
- НББХ-ийн сургалтад бүртгэлийн мэргэжлийн програмуудыг ашигладаг.

Анхаарах асуудал:

- Багш, оюутнуудын олон улсын судалгааны цахим эх үүсвэр ашиглах албан ёсны эрх хязгаарлагдмал.
- Цахим эх үүсвэрийн хангамж, шинэчлэл, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын талаарх мэдээлэл, судалгаа байхгүй.
- Цахим ном, сурах бичгийн хүрэлцээ, хангамж дутмаг, НББХ-ийн хүрээнд мэргэжлийн 3 ном цахимд байна.

Үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Зөвлөмж:

- Судалгааны цахим эх үүсвэрээр хангах тал дээр анхаарч ажиллах;
- Цахим хэрэглэгдэхүүний хангамж, сэтгэл ханамжийн судалгааг авч, судалгааны мөрөөр шаардлагатай арга хэмжээ авч ажиллах.

Шаардлага:

- Мэргэжлийн цахим ном, сурах бичгийн тоог нэмэгдүүлэх

ШАЛГУУР 3.

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Удирдах зөвлөлийн 2021 оны 8-р сарын 19-ны өдрийн 05 тоот тогтоол: ЭИС-ийн бүтцийн өөрчлөлт;
- ЭИС-ийн ректорын 2017 оны 5-р сарын 10-ны 30 тоот тушаал: Хөтөлбөрийн ерөнхий хороо (ХЕХ)-ны бүтэц зохион байгуулалт;
- 2017-2022 оны ХЕХ, 33, бүрэлдэхүүн сургууль, тэнхим (хөтөлбөрийн дэд хороо)-ийн хурлын тэмдэглэл, шийдвэр, түүний хэрэгжилтийн тайлан;
- Оюутан төгсөгчийн хөгжлийн хөтөлбөр боловсруулалт, дүрэм журам, хэрэгжилтийн тайлан;
- Хөтөлбөрийн тасралтгүй сайжруулалт, сургалтын нэгдсэн журмын хэрэгжилтийн үнэлгээ, давтамжийн тайлан;
- ЭИС-ийн хөгжлийн стратеги 2030-ийг хөгжүүлэх бодлого, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлан;
- Нягтлан бодох бүртгэл (НББ)-ийн хөтөлбөрийн стратеги 2021-2030, түүний төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан;

- НББ-ийн тэнхимийн болон багшийн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл, ахиц дэвшлийн тайлан;
- Сургалтын үнэлгээ, төлбөр, Төгсөлт, Элсэлт, шилжилт хөдөлгөөн, Суралцагч хэсгүүдээр УМС-д авч буй санал гомдлын тайлан мэдээ, хариу шийдвэрлэлтийн процесс;
- Багш суралцагчийн өргөдөл хүсэлт бичих процесс;
- Удирдлагын мэдээллийн систем(УМС) ELMS ашиглалтын үйл явц: УМС дээр байршуулсан цэс, заавар зөвлөмж, сэтгэл ханамжийн судалгаа тайлан.

Онцлог зүйл:

- Хөтөлбөрийн дэд хороо буюу тэнхим нь НББ-ийн мэргэжлийн сургалтын болон хичээлийн хөтөлбөрийг боловсруулах, үнэлэх, судалгаа авах, сайжруулах, хэрэгжүүлэхтэй холбогдох бүхий л үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж байна.
- Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрийг НББХ-ийн хөгжүүлэлтэнд тасралтгүй ашиглаж байна.
- УМС-ийн хөгжүүлэлт сайн.

Анхаарах асуудал:

- НББ-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгжид профессорын багийн зохион байгуулалтыг хөгжүүлэн сайжруулах хэрэгтэй.
- УМС-д оюутан өөрөө хичээл сонголт хийх боломж байгаа ч оюутны тоо, хичээл заах багшийн боломжоос хамаарч сонголт хийгддэггүй.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- НББХ-ийн профессорын багийн зохион байгуулалтыг хэрэгжүүлэх;
- Оюутан хичээл, багшаа өөрөө сонгох боломжийг нээлттэй байлгах.

Шаардлага: Байхгүй

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Хамтын ажиллагаатай ОХУ, БНХАУ, Япон улс зэрэг гадаадын 4, дотоодын 8 байгууллагатай явуулж буй үйл ажиллагааны мэдээ: Үүнд: ОХУ-ын Буриад улсын Дорнод сибирийн технологийн их сургууль, Эрхүү хотын Байгалийн их сургууль, БНХАУ-ын Xinyang Normal University, Солонгосын Мёнжэ болон Хангүг дээд сургуулиудтай хамтын ажиллагаатай. БНХАУ-ын “Нэг бүс нэг зам” хөгжлийн судалгааны академитэй хамтран ажиллах гэрээ байгуулсан. Лэйборфорс ХХК-ын хамтын ажиллагааны хүрээнд Япон улсад цалинтай дадлага ИЭЗМС-ийн оюутнууд хийсэн.

Илрэл нотолгоо:

- ЭЗМ-ийн тэнхим болон НББХ-ийн багш нарын төсөл хөтөлбөрт хамрагдсан тайлан, хамтран зохион байгуулсан сургалт, семинаруудын тайлан;
- НББХ-ийн багш нарт олгосон тусламж, сургалтын дэмжлэгийн мэдээ;
- НББХ-ийн оюутнуудад олгосон тэтгэлгийн мэдээ;
- НББХ-ийн мэргэжлийн хөтөлбөрийн оюутнуудын төсөлд хамрагдсан тайлан, мэдээ;
- НББХ-ийн оюутнуудын нийгэмд үзүүлсэн дадлагын үйлчилгээний мэдээ;
- Төгсөгчдийн холбооны бодлого, дүрэм журам, төлөвлөгөө;
- Төгсөчидтэй холбоотой ЭЗМТ-ийн стратегийн хэрэгжилт, тайлан мэдээ.

Онцлог зүйл:

- Нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлдэг чухал үйл ажиллагааны нэг нь “Хүн байхуй, хүний хөгжил, харилцааны ёс зүй, эрх зүй, харилцааны ур чадвар, мэргэжлийн ёс зүй” багц хичээлээр нийгмийн асуудлуудыг илрүүлэх төсөл хэрэгжүүлж, тэтгэлэг олгон үр дүнг үнэлдэг.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн эргэх холбоо, тухайлбал, давтан сургалт, түүний хэрэгжилтийн мэдээлэл хангалтгүй.
- НББХ-ийн хувьд нийгэмд үзүүлсэн багш, суралцагчдын үйлчилгээний тоон мэдээ, үр дүн тодорхойгүй.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Төгсөгчидтэй хийсэн уулзалтаар эргэх хоблоог тасралтгүй болгох, хамтарч ажиллах хөгжих сувгийг сайжруулах.

Шаардлага: Байхгүй

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Ерөнхий нягтлан бодогчоос авсан санхүүгийн тооцоолол, мэдээ;
- НББХ-ийн төсөв, түүний үр ашгийн мэдээ;
- НББХ-ийн оюутны өртөг, зардлын тооцоо;
- ЭЗМТ-ийн төсөв, түүний гүйцэтгэлийн мэдээ;
- 1 кредитийн өртөг, төлбөрийн дундаж тооцоо.

Онцлог зүйл:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн удирдлага нь сургалтын шинэ арга зүйг нэвтрүүлэх, тухайлбал, хөтөлбөрийн үр дүндчиглэсэн шинэчлэлт, өөрчлөлтөнд зориулсан сургуулийн хэмжээний төсөвтэй

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх боловсролын жилийн төсөв, гүйцэтгэлийн тайлан, түүнд хийсэн дүн шинжилгээ, засч сайжруулсан мэдээллээр хангадаг байх,
- НББ-ийн хөтөлбөр хөгжүүлэлтийн төсөв, төсвийн үр ашгийн тооцоо сайжруулах
- 1 суралцагч, 1 кредитийн төлбөр, өртгийн тооцоо уялдаа муутай.
- Нэг суралцагчид ногдох өртөг зардлын тооцоо үндсэндээ дундажаар гарсан. Тухайлбал, нийт зардлаа сургалтын ба сургалтын бус, хөрөнгө оруулалтын гэж ангилаад оюутны нийт тоонд хувааж дундаж зардлыг тооцсон. Сонирхолгүй хичээлийг өндөр кредитээр хүчээр сонгох буюу ангийн системээр хүчээр сонгуулж байна.
- Санхүүгийн ил тод байдал хангалтгүй, аудитын тайлан, зөвлөмжийг НББХ-ийн түвшинд, эсвэл ЭЗМС-ийн түвшинд хөтөлбөрийн хэрэгжилттэй холбон авч тусгаж ажилладаг нь тодорхой байх.

Үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Зөвлөмж:

- Боловсрол олгох үйл явц, боловсролын түвшний ялгаатай байдлаар сургалтын төлбөр, нэг кредитийн үнэлгээг эзэмшүүлж буй мэдлэг чадвар дадал буюу чадамжид тулгуурлан тогтоох, тухайлбал, суурь хичээлүүд, мэргэжлийн хичээлүүд, мэргэшүүлэх хичээлүүд болон дадлагын үнэлгээг ялгаатай тогтоох нь сургалтын чанар, оюутны суралцах идэвхид сайнаар нөлөөлнө.
- НББХ-ийн хөгжлийн төсөв, тайлан тооцоог сайжруулах.

Шаардлага:

- НББХ-ийн хүрэх үр дүнд чиглэсэн шинэчлэлт, өөрчлөлтөнд зориулсан төсөв, түүний гүйцэтгэл, дүн шинжилгээг тогтмол хийдэг байх;
- НББХ-ийн санхүүжилт, орлого, зардлын тооцоог ил тод байлгах. Тухайлбал, сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгааг гаргадаг байх;
- НББХ-ийн санхүүжилтийн олон эх үүсвэртэй болох, мөн хөтөлбөрт олгож буй төр хувийн хэвшлийн дэмжлэг, санхүүжилтийн зарцуулалтыг тогтмол тайлагнадаг байх.(боловсролын зээлийн бусад эх үүсвэрийг тусгах);
- Хөтөлбөрөөр суралцагчдын өртөг, үр ашгийн тооцоог тогтмол хийдэг байх;
- Нэг кредитийн өртгийг боловсролын үйлдлээр тооцож, сургалтын үнэлгээг уялдуулан тогтоодог байх;
- Багшийн хөгжлийн төсөв, түүний зарцуулалтын тайлан мэдээ, үр дүнг НББХ-ийн хөтөлбөр хэрэгжүүлэг нэгжийн хувьд тогтмол тайлагнадаг байх.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- НББХ-ийн төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаанд үндэслэсэн маркетингийн идэвхижүүлэлт хийдэг мэдээ;
- Оролцогч талуудад чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан;
- Этүгэн их сургуулийн УМС, веб сайтын мэдээлэл;
- УМС-ээр гарч буй мэдээ тайлан.

Онцлог зүйл:

- Багшийн ажлын чиг үүрэгт заавал хийх ажлын нэг болж орох ба хөтөлбөрийн маркетингийн ажилд оролцсон байдлаар ажлын үр дүнг үнэлэхэд нөлөөлдөг.

Анхаарах асуудал:

- НББ-ийн хөтөлбөрт элсэгчдийн тоо буураад байгаа тул хөтөлбөрийн элсэлттэй холбоотой маркетингийн үйл ажиллагааны үр дүнг тооцож, цаашдын үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайлан тодорхой байх.
- Хөтөлбөрийн тандан судалгааг өөрийн улалмжлалт судалгаагаар оролцогч талуудаас авч дүгнэн ном хэлбэрээр хэвлэн гаргаж ашиглаж хэвшсэн.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- НББ-ийн хөтөлбөрт элсэгчдэд тандан судалгааг тусгайлан хийж, холбогдох материалуудыг оролцогч талуудаар үнэлүүлэх байдлаар элсэлт бууралтын шалтгааныг илрүүлэх, алдаа дутагдлыг сайжруулахад анхаарах

Шаардлага: Байхгүй

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн ерөнхий удирдлагын мэдээллийн систем;
- www.etugen.edu.mn Вэбсайтын агуулга мэдээллийн иж бүрэн байдал сайн. Хөтөлбөрийн талаар www.student.etugen.edu.mn, www.teacher.etugen.edu.mn систем ил тод нээлттэй байдлын мэдээ тайлан;
- Бусад сошиал хэрэгсэл, тухайлбал, нүүр номны сүлжээ ашиглалтын мэдээ тайлан.

Онцлог зүйл:

- Оролцогч талууд үндсэн вебээс мэдээлэл авах боломжтой.

Анхаарах асуудал:

- Мэдээллийн нээлттэй ил тод байдалд цахим ном, сонин сэтгүүл, товхимол гарын авлагын хэрэглээг нэмэгдүүлэх

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Сүүлийн үеийн мэдээ мэдээллийг тасралтгүй хүргэх оролцогч талуудын мэдээллийн хэрэгцээг хангадаг тасралтгүй тогтолцоог хөгжүүлэх.

Шаардлага: Байхгүй

ШАЛГУУР 4.

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Их, дээд сургуульд оюутан элсүүлэх нийтлэг шаардлага, холбогдох хууль дүрэм, журмыг баримтлан элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулж оюутан элсүүлэн авдаг.

Илрэл нотолгоо:

- ЭИС-ийн www.etugen.edu.mn албан ёсны цахим хуудас;
- “Оюутны хөтөч” гарын авлага;
- Элсэгчдийн судалгааны тайлан;
- Суралцагчийн сэтгэл ханамжийн судалгаа, тайлан (хэвлэмэл хэлбэрээр).

Онцлог зүйл:

- ЭИС-ийн www.etugen.edu.mn албан ёсны цахим хуудасны элсэлт буланд байршуулан, жил бүрийн “Элсэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа”-нд үндэслэн мөн, элсэлтийн төлөвлөгөөний дагуу мэргэжил сурталчлах өдөрлөг, уралдаан тэмцээн, ЕБС-уудад танилцуулга, элч оюутан, багш нарын ярилцлага, сайтуудад мэдээ, элсэгчдэд зориулсан Этүгэн их сургуулийн Элсэлт-2021 гэх мэтээр жил бүрийн нүүрийн номын бүлгэмээр сургууль, тэнхим, мэргэжил сурталчилдаг.
- Зөвлөх багш (анги удирдах багш) нар томилон ажиллуулж шинэ элсэгчдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлдэг. (Баримжаа олгох 2 долоо хоног, + мэргэжлийн баримжаа олгох 1 долоо хоног2 – бүх сургуулийн захирал, ректор, УЗ-ийн дарга лекц уншдаг).
- Тухайн хичээлийн жилд мөрдөгдөх шинээр болон шинэчлэгдэн батлагдсан дүрэм, журам, мэргэжлийн хөтөлбөр, багш нарын танилцуулга, оюутны мөрдөх дүрэм журам, сургалтын үйл ажиллагааны хөтөч, оюутанд үзүүлэх үйлчилгээ зэргийг багтаасан гурван бүлэг бүхий “Оюутны хөтөч” гарын авлагыг жил бүр хэвлүүлж цахимаар болон ном хэлбэрээр элсэгчдэд түгээдэг.

Анхаарах асуудал:

- НББ-ийн хөтөлбөрт хүсэлт гаргасан болон элссэн суралцагчийн харьцаанд дүн шинжилгээ хийх талаар өөрийн үнэлгээний тайланд байхгүй ч нөхөж хийж үзүүлсэн.
- Цаашид НББХ-ийн элсэлтийг хэрхэн сайжруулах талаар төлөвлөлттэй байх.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Сүүлийн жилүүдэд элсэлт буурсантай холбоотойгоор элсэлтийн маркетингийг идэвхжүүлэх, өөрчлөх, цахимаар хүсэлт гаргасан болон элссэн суралцагчийн харьцаанд дүн шинжилгээ хийж, үр дүнгээр нь ажлаа төлөвлөж гүйцэтгэдэг байх.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Оюутанд үзүүлэх үйлчилгээний бодлого зохицуулалт нь олон төрлийн хөтөлбөрийн дагуу хэрэгждэг. 3 чиглэлээр 20 төрлийн үйлчилгээ үзүүлдэг. Оюутнуудын олон нийтийн оролцоог урамшуулдаг.

Илрэл нотолгоо:

- Оюутан, төгсөгчдийн хөгжлийн хөтөлбөр;
- Багш оюутны тооны харьцааны шинжилгээ тайлан;
- ЭИС-аас нийт суралцагсдад үзүүлдэг зөвлөх үйлчилгээний тайлан;
- Зөвлөн туслах үйл ажиллагааны сэтгэл ханамжийн судалгаа, тайлан;
- УМС-ийн оюутанд зориулсан заавар зөвлөмж, хэрэгжилтийн тайлан;
- Суралцагчид зориулсан сургалт, эрдэм шинжилгээ, арга хэмжээний тайлан.

Онцлог зүйл:

- Этүгэн ирвэсүүд, Усан бассейн, Номын сан, Амжилт фитнесс, Этүгэн мед, Сэтгэлзүйн төв гэх мэт олон үйл ажиллагаанд НББХ-ийн оюутнууд хамрагдах бүрэн боломжтой, хөнгөлөлттэй, урамшуулалтай.
- Элссэнээс төгсөх хүртэл зөвлөх багш ажиллаж, асуудлыг хамтран шийдвэрлэдэг.
- Оюутны сэтгэл ханамжийн судалгааг сургалтын байгууллагын үндсэн чиглэлүүдээр авч нэгтгэн дүгнэсэн.
- Суралцагчид сургалт арга хэмжээний тайлантай. Тэр дундаа, НББХ-ийн суралцагчдад 13 төрлийн сургалт арга хэмжээний төлөвлөгөө, тайлантай.

Анхаарах асуудал:

- НББХ-ийн хувьд зөвлөх, оюутныг хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, тайлан байхгүй.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Оюутанд зөвлөн туслах, тэднийг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж ажиллан, НББХ-ийн оюутнууд бие биеэсээ хамтран суралцах, бие биедээ зөвлөн туслах тогтолцоог хөгжүүлэх.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо сайн. Тухайлбал, урамшуулал, тэтгэлэг, хөнгөлөлтөд сайн хамрагддаг.

Илрэл нотолгоо:

- Оюутан, төгсөгчдийн хөгжлийн хөтөлбөр;
- Оюутны холбооны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан;
- Нийгэм хамт олонд үйлчлэх дадлагын тайлан;
- Суралцагсдын олимпиад, уралдаан тэмцээнд оролцсон амжилтуудын мэдээ;
- “Этүгэн энтрепрейнер” хөтөлбөрийн “Этүгэн инноваци” өдөрлөгт НББХ-ийн оюутнууд амжилттай оролцож төсөл хэрэгжүүлсэн тайлан мэдээ;
- Суралцагчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмждэг арга хэмжээнүүдийн тайлан мэдээ;
- Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөнд хамрагдсан оюутны мэдээ тайлан.

Онцлог зүйл:

- Хүн байх гэсэн зарчмаар олон нийтийн ажилд оюутнуудаа оролцуулдаг.
- Этүгэн энтрепренёр хөтөлбөр, Этүгэн инновац өдөрлөг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Этүгэн сан” тус тус үйл ажиллагаа явуулж байна.
- Улсын болон олон улсын чанартай уралдаан тэмцээн, олимпиад, тэтгэлэгт хамрагдсан мэдээлэл судалгаатай.
- НББХ-ийн мэргэжлийн чиглэлийн 6 төрлийн уралдаан тэмцээнд сүүлийн 5 жилд 3-аас доошгүй тэмцээн уралдаанд тогтмол оролцож амжилт үзүүлсэн.

Анхаарах асуудал:

- Клуб дугуйлангийн батлагдсан жилийн ажлын төлөвлөгөө, зохион байгуулсан арга хэмжээний тайлан байхгүй.
- Багш нарын зүгээс оюутны олон нийтийн ажлын оролцоог хэрхэн дэмжиж хамтран ажилладаг нь тодорхойгүй.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- НББХ-ийн хөгжүүлэлтэнд олон нийтийн оролцоо, урамшууллын хөгжүүлэх.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу шийдвэрлэдэг.

Илрэл нотолгоо:

- УМС-ийн цэсэнд байгаа шилжилт хөдөлгөөний үйл явц;
- НББХ-ийн суралцагчийн шилжилт, хөдөлгөөний тайлан мэдээ.

Онцлог зүйл:

- Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой судалгааг тогтмол авч хэвшсэн.
- Гадаад оюутны дүн, тооцоог хөрвүүлэх журмаа гаргасан.

Анхаарах асуудал:

- Жилийн чөлөө авах, жилийн чөлөөнөөс эргэн ирэх, мэргэжил сонголттой холбоотой шилжилт хөдөлгөөн их гардаг. Бусад шилжилт хөдөлгөөнд шинжилгээ судалгаа хийх

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Жилийн чөлөө, мэргэжил солих гэсэн 2 сонголтаар шилжилт хөдөлгөөнийг зохицуулж байгаа нь бусад хүчин зүйлсийг орхигдуулах эрсдэлтэйг анхаарах.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Төгсөлтийн баримт бичгүүд стандарт шаардлагын дагуу боловсруулагдсан. Төгсөлтийн үйл ажиллагаа холбогдох журмын дагуу зохион байгуулагддаг

Илрэл нотолгоо:

- Төгсөлтийн дүрэм журам, төгсөлтийн үйл ажиллагааны үйл явц;
- Төгсөлтийн баримт бичиг олго үйл явц, судалгаа, тайлан;

Онцлог зүйл: Байхгүй

Анхаарах асуудал:

- Төгсөгчдөөс судалгаа авдаг боловч эргэх холбоо сул, ажил олгогчтой хамтын ажиллагаа тодорхой бус.
- Төгсөх оюутны төгсөлтийн ажил, улсын шалгалт, шат шатны хэлэлцүүлгийн талаарх НББ-ийн мэргэжлийн байгууллагын дүгнэлт, санал зөвлөмжийг хөтөлбөрийн хөгжүүлэлтэнд тусган ажиллах

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Төгсөгчдөөс ажил эрхлэлт, кареер өсөлт, хатуу зөөлөн ур чадварыг эзэмшсэн байх зэргээр судалгаа авч дүгнэн хөтөлбөрийн сайжруулалтанд тусгах;
- Холбогдох асуудлаар мэргэжлийн байгууллага, холбоодын санал, зөвлөмжийг авч, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх.

ШАЛГУУР 5.**ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН****Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа**

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Багш, ажилтны мэдлэг, чадвар, ёс зүйд суурилсан нээлттэй сонгон шалгаруулалтын үйл явцыг мэргэжлийн тэнхим, бүрэлдэхүүн сургууль, сургалтын бодлого зохицуулалтын алба, ректор гэсэн үе шаттайгаар тусгай удирдамжийн дагуу дараах дүрэм журмыг удирдлага болгон явуулдаг.

Илрэл нотолгоо:

- Монгол улсын хөдөлмөрийн тухай хууль;
- ЭИС-ийн “Хөдөлмөрийн дотоод журам”;
- ЭИС-ийн дүрэм, журмын эмхэтгэл, 2015;
- Хүний нөөцийн бодлогын баримт бичиг батлах тухай ЭИС-ийн ректорын 2021 оны 04 сарын 01 өдрийн 27 тоот тушаалын хавсралт 1;
- ЭИС-ийн сургалтын нэгдсэн журамд оруулах нэмэлт. ЭИС-ийн ректорын 2021 оны 12 сарын 21 өдрийн 146 тоот тушаалын хавсралт;
- Багшийн сэтгэл ханамжийн судалгааны эмхэтгэл, 2022;
- ЭИС-ийн багшийн ажлын дэвтэр;
- ЭИС-ийн багшийн албан тушаалын ангилалд тавигдах шаардлага.

Онцлог зүйл:

- Салбарын мэргэшсэн, мэргэжлийн өндөр ур чадвартай эрдэмтэн, багш, судлаачдыг тусгай нөхцөлөөр урьж ажиллуулдаг. Гурван шинжлэх ухааны доктор, нэг боловсролын доктор зөвлөх багшаар ажилладаг.

Анхаарах асуудал:

- Сонгон шалгаруулалтад баримтлах бичиг баримтад Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тавигдах нийтлэг шаардлагыг оруулах.

Үнэлгээ: Бүрэн хангасан**Зөвлөмж:**

- Хүний нөөцийн сонгон шалгаруулалтын үе шатыг цөөлөн хүний нөөцийн алба нэгжтэй болж зохион байгуулалт хийх

Шаардлага: Байхгүй

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Багшийн хөгжлийн дэмжих тухай хууль, “Багшийн хөгжлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай” засгийн газрын тогтоолыг үндэс болгон багшийн хөгжлийн хөтөлбөрийг 1 болон 5 жилээр боловсруулан хэрэгжүүлдэг.

Илрэл нотолгоо:

- Багшийн хөгжлийн хэрэгцээний судалгаа;
- Багшийн хөгжлийн 5 жилийн хөтөлбөр. ЭИС-ийн ректорын 2021 оны 04 сарын 20 ны өдрийн 33-р тушаалын хавсралт;
- СБЗА-ны даргын хичээлийн жилийн эхэнд баталгаажуулсан СБЗА-ны даргын хичээлийн жилийн эхэнд баталгаажуулсан “Багшийн хөгжлийн 1 жилийн хөтөлбөр”;
- Багшийн хөгжлийн хөтөлбөрт хамрагдсан багш нарын сэтгэл ханамжийн судалгааны нэгтгэл;
- Багшийн хөгжил хариуцсан нэгж байгуулах тухай ЭИС-ийн ректорын 2020 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 96 тоот тушаал;
- ЭИС-ийн дүрэм, журмын эмхэтгэл, 2015.

Онцлог зүйл:

- Багшийн хөгжлийн онцлог нь багшийн зэрэглэл, туршлага, ажилласан жилд тохируулан модуль сургалт зохион байгуулах ажил тогтмол явдаг. Модуль сургалтын сэтгэл ханамжийн судалгаан дээр үндэслэн сургалтын агуулгат тогтмол шинэчлэл хийдэг.
- Багшийн хөгжлийг хангах бодлогын баримт бичиг, түүний хэрэгжилтийг хангах бодит орчин, дүрэм, журмыг иж бүрнээр бүрдүүлсэн

Анхаарах асуудал:

- Багшийн хөгжлийн төв нь сургалтын бодлого зохицуулалтын албандаа харьяалагддаг. ЭИС нь 217, гэрээт 139, нийт 356 багштайгаар сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа тул “Багшийн хөгжлийн төв” -ийг бие даасан нэгж болгон ажиллуулах.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Багш нарыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн судлаач болох тал дээр анхааран ажлын ачааллыг өөрийгөө хөгжүүлэх боломжтойгоор төлөвлөх

Шаардлага: Байхгүй

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Хөтөлбөрийн багш нарын эрдэм судлалын бүтээлийг сүүлийн 5 жилээр нэгтгэвэл нийт 51 дотоод өгүүлэл, гадаад 11 өгүүлэл, дотоодод 48 илтгэл, гадаадад 9 илтэл, сурах бичиг 13, төсөлт ажил 7, нэг сэдэвт бүтээл 68 ашигтай загварын гэрчилгээ 17, нийт 162 эрдэм судлалын бүтээл хийж сургалтын хөтөлбөрт холбогдох чиглэлээр нутагшуулсан байна. 2020-2022 онд нийт 11 төсөл хэрэгжиж байгаагаас 7 төсөл дууссан, хэрэгжиж байгаа нь 4 төсөл. Энэхүү төсөл хөтөлбөрүүдэд нягтлан бодох бүртгэл мэргэжлийн 4 багш оролцсон байна.

Илрэл нотолгоо:

- “ЭИС-ийн эрдэм шинжилгээ, инновацын төсөл хэрэгжүүлэх журам”. Ректорын 2021 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 42 тоот тушаалын хавсралт 1;
- “ЭИС-ийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн батлах тухай” удирдах зөвлөлийн 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 05 тоот тогтоол;
- ЭИС-ийн “Хөдөлмөрийн дотоод журам”;
- ЭИС-ийн дүрэм, журмын эмхэтгэл, 2015;
- “Эрдмийн зул” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл 2020, 2021, 2022.

Онцлог зүйл:

- Тэргүүлэх чиглэлийн хүрээнд суралцагчид, багш эрдэмтэн, судлаачдын энтрепренёр сэтгэлгээ, шинэлэг санаанд тулгуурлан бизнесээ бодит ажил хэрэг болгох чадамж олгох, хамтран ажиллах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, инновац дээр суурилсан гарааны бизнесийг бий болгох зорилготой Этүгэн энтрепренёр хөтөлбөр хэрэгжүүлдэг.

Анхаарах асуудал: Байхгүй

Үнэлгээ: *Бүрэн хангасан*

Зөвлөмж: Байхгүй

Шаардлага: Байхгүй

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- ЭИС-ийн дүрэм, журмын эмхэтгэл, 2015;
- “Багшийн ажлын ачаалал тооцох” журам;
- Хөндлөнгийн үнэлгээ хийх журам;
- Багшийн ажлыг үнэлэх журам;
- Багшийн ажлын дэвтэр.

Онцлог зүйл:

- ЭИС-д тогтвор суурьшилтай, үр дүнтэй ажиллаж байгаа багш нартай үр дүнгийн болон хөрөнгө оруулалтын гэрээ хийх шийдвэрийг удирдах зөвлөл, ректор баталж хэрэгжүүлдэг.
- Багшийн ажлын үр дүнг үнэлэх бодлогын баримт бичигтэй, түүнийгээ хатуу мөрдөж ажилладаг.

Анхаарах асуудал: Байхгүй

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж: Байхгүй

Шаардлага: Байхгүй

ШАЛГУУР 6.**ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН****7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- ЭИС-ийн дүрэм, журмын эмхэтгэл, 2015;
- Үйл ажиллагааны дотоод хяналт, чанарын баталгаажуулалтын гарын авлага, 2021;
- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын систем;
- Хөтөлбөрийг боловсруулахад оролцогч талуудаас авсан судалгааны тайлан;
- “Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх тухай” журам;
- Чанарын баталгаажилт архив;
- Хөтөлбөрийн ерөнхий, салбар, дэд хороо байгуулах тухай ЭИС-ийн ректорын 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 30 тоот тушаал;
- Хөтөлбөрийн хорооны журам;
- Хөтөлбөрийн ерөнхий хорооны төлөвлөгөө, тайлан 2017 оноос хойш.

Онцлог зүйл:

- Хөтөлбөрийг хэрэгжилтийг хангахад чиглэсэн чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог “Стратеги төлөвлөгөө 2030”-д тодорхойлсон.
- Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн дотоод болон хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэн, холбогдох дүрэм, журмыг баталсан.
- Хөтөлбөрийг баталгаажуулах үйл ажиллагааны оролцогч талуудыг тодорхойлсон.

Анхаарах асуудал: Байхгүй

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж: Байхгүй

Шаардлага: Байхгүй

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- ЭИС-ийн дүрэм, журмын эмхэтгэл, 2015;
- Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх журам;
- Чанарын гарын авлага;
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгааны нэгтгэл, 2019, 2020, 2022;
- Ажил олгогчоос авсан сэтгэл ханамжийн судалгааны эмхгэл, 2019-2020;
- Оюутны сэтгэл ханамж, 2020-2021 оны хичээлийн жил, харьцуулсан судалгаа.

Онцлог зүйл:

- Чанарын баталгаажуулалт, хөтөлбөрийн үр дүнг үнэлэх, түүнд нөлөөлөх хүчин зүйл, санал асуулгын хамт сүүлийн 5 жилд улирал бүр тасралтгүй зохион байгуулж, судалгааны дүгнэлт анализыг үндэслэн цаг тухай бүрд нь шийдвэрлэн шаардлагатай арга хэмжээг авч ажилладаг.
- Хөтөлбөр, хичээлийн үр дүнгийн үнэлгээ, гарааны үнэлгээ, ахиц, төгсөлтийн үнэлгээний үр дүнд үндэслэн хичээлийн хөтөлбөрийн үр дүн, заах арга зүй, үнэлгээ, хичээл хоорондын залгамж холбоо, мэргэжлийн хөтөлбөрийн сайжруулалт тогтмол хийгддэг.

Анхаарах асуудал: Байхгүй

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж: Байхгүй

Шаардлага: Байхгүй

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

2014 онд Нягтлан бодох бүртгэл хөтөлбөр ASBSP олон улсын магадлан итгэмжлэлд орсон. ASBSP-ээс тус хөтөлбөрийг монголын дундаж үнэлгээтэй харьцуулахад ДУНДАЖ гэсэн үнэлгээ өгсөн. Төгсөгчдөд үүссэн давуу байдал ASBSP магадлуулсан орнуудад диплом хүлээн зөвшөөрөгдөнө.

Илрэл нотолгоо: /

- ЭИС-ийн дүрэм, журмын эмхэтгэл, 2015;
- ASBSP-д хүргүүлсэн өөрийн үнэлгээний тайлан, 2016, 2019, 2022;
- ASBSP с ирсэн хөндлөнгийн үнэлгээний тайлан, 2022 он хүртэлх;

Онцлог зүйл:

- АНУ-ын Бизнесийн сургууль, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн холбоо (ACBSP)-гоор магадлан итгэмжлэл хийлгэсэн.
- Преграйн Академик сервис байгууллагатай хамтран жил бүр элсэгч оюутнуудаас гарааны шалгалт, төгсөгч оюутнуудаас гарцын шалгалтыг тогтмол зохион байгуулж, сургалтын үр дүнгийн анализ хийн ажилладаг.

Анхаарах асуудал: Байхгүй

Үнэлгээ: *Бүрэн хангасан*

Зөвлөмж: Байхгүй

Шаардлага: Байхгүй

ШАЛГУУР 7.

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН

ДҮГНЭЛТ
ЭИС-ийн Эдийн засаг, менежментийн сургуулийн Нягтлан бодох бүртгэл
бакалаврын сургалтын хөтөлбөр

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			
2	Сургалтын үйл ажиллагаа	2			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			
6	Багшийн үйл ажиллагаа	2			
7	Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	2			
Дүгнэлт		Бүрэн хангасан			

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Шалгуур	Зөвлөмж
1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> • Гадаадын их, дээд сургуулийн хөтөлбөрийн харьцуулсан судалгаа, мэргэжлийн байгууллага, холбоодын санал, зөвлөмжийг хөтөлбөрийн шинэчлэл, сайжруулалтад тусгаж ажиллах • Хөтөлбөрийн зорилго, зорилт (PEO) болон суралцахуйн үр дүн (PLO), хичээлийн болон тухайн сэдвийн үр дүнгийн хоорондын уялдаа холбоог сайжруулах • Суралцагчид цахим орчинд ажиллах ур чадвар олгох талаар анхаарч ажиллах
2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Хичээлийн залгамж холбоог нарийн баримталж сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах • Оюутны сонголт хийх боломжийг дэмжих
3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	<ul style="list-style-type: none"> • Суралцагч, төгсөгчдөөс сургалтын орчны талаар авсан сэтгэл ханамжийн судалгааны мөрөөр авах арга хэмжээг сайжруулах • Багш, суралцагчдын ашиглах боломжтой судалгааны болон мэргэжлийн ном сурах бичгийн цахим эх үүсвэрийг нэмэгдүүлэх
4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> • НББХ-ийн профессорын багийн зохион байгуулалтыг хэрэгжүүлэх; • Төгсөгчдийн эргэх холбоог сайжруулах

		<ul style="list-style-type: none"> • НББХ-ийн хөгжлийн төсөв, тайлан тооцоог сайжруулах.
5.	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Суралцагч, төгсөгчийн зөөлөн, хатуу ур чадварын судалгаа, ажил эрхлэлт, карьер өсөлтийн судалгаа зэргийг НББХ-ийн түвшинд тогтмол хэрэгжүүлдэг байх • НББХ-ийн мэргэжлийн байгууллага, холбоодын санал зөвлөмжийг хөтөлбөр хөгжүүлэлтэнд тусган ажилладаг байх • НББХ-ийн элсэлтийн маркетингийг идэвхижүүлэх
6.	Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Хүний нөөцийн сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулах • Багш нарын судалгаа, шинжилгээний ажил хийх боломжийг нэмэгдүүлэх, тусалж дэмжих
7.	Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	<ul style="list-style-type: none"> • Байхгүй
Шалгуур		Шаардлага
3.	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	<ul style="list-style-type: none"> • Мэргэжлийн цахим ном, сурах бичгийн тоог нэмэгдүүлэх
4.	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> • НББХ-ийн хүрэх үр дүнд чиглэсэн төсөв, түүний гүйцэтгэлийн тайлан, шинжилгээг ашигладаг байх • НББХ-ийн хөтөлбөрөөр суралцагчийн өртөг, үнэлгээг боловсролын үйлдэл, циклээр харуулдаг байх

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Этүгэн их сургуулийн Эдийн засаг, менежментийн сургуулийн “Нягтлан бодох бүртгэл” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....

V. Уулзалт ярилцлагад оролцогчдын бүртгэл

I. Багш нартай хийх уулзалт

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1.	А.Даваасүрэн	Тэнхимийн эрхлэгч	Доктор (Sc.D), профессор	2	<ul style="list-style-type: none"> Эдийн засгийн онол
2.	Ю.Туул	Профессор	Доктор	9	<ul style="list-style-type: none"> Микро эдийн засаг Макро эдийн засаг Статистикийн онол
3.	О. Лхагварэнцэн	Профессор	Доктор, профессор	6	<ul style="list-style-type: none"> Төсөвт байгууллагын бүртгэл Бизнесийн эрх зүй Татварын хураалт, хяналт, шалгалт
4.	Ж. Пүрэвсүрэн	Дэд профессор	Магистр	10	<ul style="list-style-type: none"> Санхүүгийн үндэс Аж ахуйн нэгжийн санхүү Санхүүгийн менежмент Санхүүгийн тайлангийн шинжилгээ Санхүүгийн хяналт, шалгалт
5.	Ц. Уранцэцэг	Ахлах багш	Магистр	8	<ul style="list-style-type: none"> Бизнесийн ёс зүй Эрсдэлийн менежмент Менежментийн үндэс
6.	Б.Учрал	Ахлах багш	Магистр	8	<ul style="list-style-type: none"> Албан хэргийн менежмент Энтерперенёр
7.	Э.Отгонцэцэг	Багш	Магистр	8	<ul style="list-style-type: none"> Маркетингийн үндэс
8.	Б. Даариймаа	Ахлах багш	Магистр, Мэргэшсэн нягтлан бодогч, Татварын мэргэшсэн зөвлөх	10	<ul style="list-style-type: none"> НББ-ийн үндэс Санхүү бүртгэл-1 Санхүүгийн дунд шатны НББ - 1 Татварын бүртгэл Харилцааны ур чадвар
9.	С.Мөнхжаргал	Багш	Магистр	5	<ul style="list-style-type: none"> Төслийн менежмент
10.	Ц.Сэрчмаа	Багш	Магистр	5	<ul style="list-style-type: none"> Санхүүгийн дунд шатны НББ - 2 Өртгийн бүртгэл-1 Санхүүгийн ахисан шатны НББ СТОУС Кейс сургалт Санхүү бүртгэл -2
11.	Г.Өлзийбаяр	Багш	Магистр	6	<ul style="list-style-type: none"> НББ-ийн мэдээллийн систем

II. Оюутан, суралцагчидтай хийх уулзалт

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
1.	Н.Бүжмаа	3	Ангийн дарга
2.	Б.Ариунзаяа	3	Идэвхтэн сурлагатан
3.	М.Жандос	3	Баян-Өлгий оюутан
4.	Д.Сумъяабаяр	3	Идэвхтэн сурлагатан
5.	О.Ундрал	3	Идэвхтэн сурлагатан
6.	А.Энхжин	3	Голч өндөр
7.	Н.Халиун	3	Сагсны шигшээ
8.	Ц.Эрдэнэзул	3	Идэвхтэн сурлагатан
9.	Д.Даваадулам	3	Төрийн сан
10.	П.Даваажаргал	3	Голч бага
11.	Б.Мягмардорж	3	Идэвхтэн сурлагатан
12.	Т.Баяраа	3	Идэвхтэн сурлагатан
13.	Б.Энхцацралт	2	Ангийн дарга
14.	А.Анхзаяа	2	Голч өндөр
15.	Н.Бадамханд	2	Идэвхтэн сурлагатан
16.	Б.Мөнхжаргал	2	Гар бөмбөгийн шигшээ
17.	Д.Цогтбаатар	2	Идэвхтэн сурлагатан
18.	Г.Сондор	2	Идэвхтэн сурлагатан
19.	Б.Ерназар	2	Баян-Өлгий оюутан
20.	С.Сэлэнгэмөрөн	2	Голч бага

III. Ажил олгогчидтой хийх уулзалт

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал	Утас
1.	Б.Өрнөхжаргал	Таван богд Финанс	Гүйцэтгэх захирал	99068468
2.	Г.Баярцэцэг	Цэцэгт мэндчилгээ.	Салбарын менежер	95607560
3.	Ч.Ариунцэцэг	Цэц актив ХХК	Ерөнхий нягтлан бодогч	99090668
4.	Г.Болорцэцэг	Колорланд ХХК	Гүйцэтгэх захирал	88090809
5.	Ц.Алтанзул	Тахе монголиа ХХК	Хүний нөөцийн менежер	91074488
6.	Т.Одонтуяа	Төрийн өмчит “Мэдээлэл холбоо сүлжээ” ХХК	Маркетингийн хэлтсийн дарга	88880611
7.	Р. Амарсайхан	Цахиур Төмөр Агар ХХК	Гүйцэтгэх захирал	88902623
8.	Ж.Отгончимэг	Цукуба ХХК	Ерөнхий нярав	99089583
9.	М.Тунгалаг	Газаркаптал партнерс ББСБ	Санхүү эрхэлсэн захирал	95953855
10.	Н.Бүрэнтэгш	Алтан Ширээ сумын	Засаг дарга	91104422

IV. Төгсөгсөгчидтэй хийх уулзалт

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал	Утас
1.	Ч.Амартүвшин	2013	Хангууд пропертис ХХК	Гүйцэтгэх захирал	80116009
2.	Н.Маралмаа	2014	Аэромонголиа ХХК	Ерөнхий нягтлан бодогч	99994263
3.	Г.Жавзандулам	2017	Цэцэгт мэндчилгээ ХХК	Тооцооны нягтлан бодогч	95734445
4.	Б.Данзандорж	2018	Мэжик Консалтинг Аудит ХХК	Ахлах нягтан бодогч	80015274
5.	Д.Ганзориг	2019	Грийн груп, Грийн Индастри ХХК	Ахлах нягтан бодогч	95778885
6.	О.Хонгорзул	2019	Газар капитал ХХК	Ахлах нягтан бодогч	95953755
7.	Н.Айжархан	2021	Хурдны зам ХХК	Ахлах нягтан бодогч	99823455
8.	Э.Эрдэнэсүвд	2021	СБД-ийн татварын хэлтэс	Татварын байцаагч	99790142
9.	Э.Гантуяа	2022	Марал дизайн ХХК	Нягтан бодогч	96118796

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)

Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт...

Зөвлөмж....

Шаардлага...

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

VII. Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан

(огноо).....

Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт...

Зөвлөмж....

Шаардлага...

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

